



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/515

Чингис хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 161 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам"-ын 1.4, аймгийн Онцгой комиссын 33 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймаг, сум, баг, хот хоорондох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг Улсын Онцгой комиссоос тогтоосноос бусад тохиолдолд 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд хязгааралсугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн ам олноор цугларах газрууд болох барааны зах, худалдааны төв, сүм хийд, бар, зоогийн газар, ресторан, караокены үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд зогсоож, архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг мөн хугацаагаар хориглосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлж хавсралтаар баталсугай.

4. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд /ганц бие эцэг/ байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг ажилласанд тооцож олгохыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад үүрэг болгосугай.

5. Төрийн байгууллагын ажиллах цагийн хуваарийг 09:00-16:00, хүнсний дэлгүүр, хүнсний захын ажиллах цагийн хуваарийг 09:00-17:00 цагаар тогтоож, шатахуун түгээх станц, эмийн сангуудыг ердийн цагийн хуваарийн дагуу халдвар хамгаалалтын дэглэмийг

231010942

2.

чанд мөрдүүлж ажиллуулсугай.


6. Үзвэр, үйлчилгээний газрууд болон элэн нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоосон хугацаагаар хязгаарласугай.

7. Бүх нийтийн бэлэн байдлын үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомстол үүсгэхгүй байхыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, хүнсний худалдаа эрхлэгч нарт үүрэг болгосугай.


8. Хүнсний хэрэгцээт бараа худалдан авах, эмийн болон эмнэлгийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг нийт иргэдэд анхааруулсугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ



Аймгийн Засаг даргын 2020 оны  
11 дугаар сарын 18 өдрийн А/515  
дугаар захирамжийн хавсралт

<b>Нэг. Зайнаас ажиллах байгууллага</b>	
1.	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс
2.	Статистикийн хэлтэс
3.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
4.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
5.	Мал эмнэлгийн газар
6.	Харгуй ХК
7.	Хэрлэн голын сав газрын захиргаа
8.	Биеийн тамир, спортын газар
9.	Боловсрол, соёл, урлагийн газар
10.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
11.	Музей
12.	Номын сан
13.	Хан Хэнтий чуулга
14.	Политехник коллеж
15.	Орон нутгийн өмчийн газар
16.	Санхүүгийн хяналт, аудитын алба
17.	Татварын хэлтэс
18.	Улсын бүртгэлийн хэлтэс
19.	Насан туршийн боловсрол төв
20.	Прокурорын газар
21.	Төрийн аудитын газар
22.	Шуудан үйлчилгээний газар
23.	Аймгийн шүүх
24.	Нийгмийн даатгалын хэлтэс
<b>Хоёр. Зөвхөн шаардлагатай ажилтнууд ажиллах байгууллага</b>	
1.	Аймгийн ИТХ
2.	Аймгийн Засаг даргын Тамгын газар
3.	Хэрлэн сумын ЗДТГ
4.	Нийтлэг үйлчилгээний газар ОНӨҮГ
5.	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
6.	Хүнс, хөдөө аж ахуйн газар
7.	Авто тээврийн төв
8.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
9.	Өндөрхаан нисэх буудал
<b>Гурав. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах байгууллага</b>	
1.	Мэргэжлийн хяналтын газар
2.	Хот тохижилт үйлчилгээний газар
3.	Хэнтий-Ус ХХК
4.	Цахилгаан түгээх сүлжээ салбар
5.	Цахилгаан холбоо
6.	Мэдээлэл холбоо сүлжээ
7.	Эрүүл мэндийн газар
8.	Зооноз өвчин судлалын төв

9.	Уламжлалт- анагаах ухааны төв
10.	Онцгой байдлын газар
11.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги
12.	Шүүхийн шинжилгээний алба
13.	Цагдаагийн газар
14.	Нэгдсэн эмнэлэг
15.	Тагнуулын хэлтэс
16.	Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн Хэнтий аймаг дахь салбар

-oOo-